

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
/2025-2029 он/**

НЭГ. АЛСЫН ХАРАА

Боловсролын байгууллагууд нь үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнгээрээ улсын хэмжээнд тэргүүлэгч байна.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Иргэн бүрийг эрдэм боловсролтой Монгол хүн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн арга зүй, мэргэжлийн туслалцааг боловсролын байгууллагуудад үзүүлж, сургалтын байгууллагын менежментийг төлөвшүүлнэ.

ГУРАВ. ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсролын газар нь төрийн албанд мэдлэгтэй, чадвартай, хариуцлагатай, шударга, ил тод байдлыг ханган ажиллаж, үйл ажиллагаандаа дараах зүйлийг эрхэмлэнэ.

Мэдлэг, чадвартай байх : Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэх хангалттай чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх,

Хамтын ажиллагаа: Нэгдсэн зохион байгуулалтай, хөрвөх чадвартай мэргэшсэн, чадварлаг хамт олонд түшиглэсэн багийг бүрдүүлж ажиллах,

Хариуцлагатай байх: Нийгмийн өмнө хүлээсэн төрийн албаны манлайлал, үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, ажилдаа чин сэтгэлээсээ бүтээлч, санаачилгатай, хуулийг дээдлэн ажиллах,

Санаачилгатай байх: Боловсролын газар нь шинэ санал, санаачилгаар бусдыг үлгэрлэн дагуулах,

Үйлчилгээг хэрэглэгчдэд чиглүүлэх: Үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгийг үзүүлж, өөрийн үйл ажиллагаагаараа тэдний итгэл, хүндэтгэлийг хүлээж ажиллах,

Ёс зүй, шударга, нээлттэй байх: Төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан, соёлтой, шударга, ил тод нээлттэй, тэгш байдлыг эрхэмлэх,

Таатай орчинтой байх: Албан хаагчдын хөгжих, мэдлэг чадвараа тасралтгүй сайжруулах, санал, санаачилгыг дэмжсэн ажлын байрны таатай орчинг бүрдүүлнэ.

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МАНДАТ

4.1. Тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуульд удирдлагын болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх,

4.2. Боловсролын байгууллагын удирдах ажилтан, багш, иргэнд боловсрол, мэргэжил эзэмших, мэргэшлээ дээшлүүлэх судалгаа, шинжилгээ эрхлэхэд нь туслах

4.3. Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах

4.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймгийн Засаг даргад санал болгох

4.5. Боловсролын салбарын багш, ажилтнуудын хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

4.6. Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх

4.7. Боловсролын талаарх тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх

4.8. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох

4.9. Орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал цэцэрлэгийн эрхлэгчийн сул орон тооны захиалгыг төрийн албаны салбар зөвлөлд хүргэх, сул орон тоог тухай бүр нөхөх үйл ажиллагааг зохион байгуулах

ТАВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

5.1. Суралцагч, багш, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх

5.2. Боловсролын салбарын менежмент, үйлчилгээний чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх, нэгдсэн бодлого төлөвлөлт хэрэгжүүлэх

5.3. Боловсролын салбарын санхүү, хөрөнгө оруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, үр ашигтай зарцуулах

ЗУРГАА. ҮЙЛ АЖИЛЛАГАА

Стратегийн зорилт 1-ийн хүрээнд: “Суралцагч, багш, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх” **зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

6.1.1. Боловсролын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг байгууллага, олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, үр дүнг тооцон ажиллах

6.1.2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсролын салбарыг хөгжүүлэх орон нутгийн бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах

6.1.3. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй, технологи хэрэгжүүлэхэд багш, удирдах ажилтнуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах,

6.1.4. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр, төслийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах,

6.1.5. Бага, суурь, бүрэн дунд боловсролын талаарх хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр, төслийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах,

6.1.6. Багш, удирдах ажилтнуудыг нарыг чадавхжуулах давтан сургах, мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хангах үйл ажиллагааг зохион байгуулах, тэдний хэрэгцээнд суурилсан зөвлөгөө дэмжлэг үзүүлэх

6.1.7. Хүүхдийн хөгжил төлөвшил, авьяас, чадварыг нээн хөгжүүлэх, тэдний чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх чиглэлээр хүүхдийн болон мэргэжлийн бусад байгууллагатай хамтран ажиллах,

6.1.8. Орон нутагт боловсролын чанарын үнэлгээний судалгаа хийх, элсэлтийн шалгалт, байгууллага болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, үр дүнг тооцон ажиллах

Стратегийн зорилт 2-ын хүрээнд: “Боловсролын салбарын менежмент, үйлчилгээний чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх” **зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

6.2.1. Боловсролын салбарын статистик мэдээллийг боловсронгуй болгох, удирдлагын мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдал, цахим үйл ажиллагааг хангах,

6.2.2. Боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалт, салбарын хүний нөөцийн тасралгүй хөгжлийг хангах,

6.2.3. Орон нутгийн боловсролын байгууллагын хүний нөөцийн менежментийг сайжруулах,

6.2.4. Боловсролын салбарын нэгж байгууллагуудын архивыг стандарт, шаардлагын дагуу тохижуулах, албан хэрэг хөтлөлт, байгууллагын архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх чиглэлээр зөвлөн туслах, арга зүйн удирдлагаар хангах

6.2.5. Багш, ажилтан харилцан туршлага солилцох, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, сайн туршалга үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, нийтийн хүртээл болгох

6.2.6. Салбарын багш, ажилтан, суралцагчийн бүтээлч үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, урамшуулан дэмжих,

6.2.7. Сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагын үйл ажиллагааны чанар, үр дүнг үнэлэх, хяналт- шинжилгээ хийх

6.2.8. Сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллага, багшийн үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод хяналт-шинжилгээний тогтолцоо төлөвшүүлэх,

6.2.9. Багшийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг арга зүйн удирдамжаар хангах, багш, ажилтан ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах,

6.2.10. Хүүхдийн хоол, хүнсний хангамж, хоол үйлдвэрлэл үйлчилгээг тогтмол сайжруулах, хүнийн нөөц болон тоног төхөөрөмжөөр бүрэн хангах хэрэгжилтэд хяналт тавих, аюулгүй байдлыг хангахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх,

6.2.11. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг шинээр байгуулах, татан буулгах асуудлаар дүгнэлт гаргах,

6.2.12. Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, бүс нутгийн онцлог, хүн амын нягтрал, хэтийн төлөв, цэцэрлэг, сургуулийн барилгын хүчин чадал, нөөцийг харгалзан цэцэрлэг, сургуулийн хамран үйлчлэх тойрог тогтоох, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдамж, зохицуулалтаар хангах, хяналт тавих.

6.2.13. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг нэгдсэн загварын дүрэмт хувцсаар хангах үйл ажиллагааг зохион байгуулах

6.2.14. Орон нутгийн боловсролын байгууллагын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх,

6.2.15. Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ, дүгнэлт хийх,

Стратегийн зорилт 3-ын хүрээнд: “Боловсролын салбарын санхүү, хөрөнгө оруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, үр ашигтай зарцуулах” зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.3.1. Салбарын хөрөнгө оруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зохицуулалтыг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх;

6.3.2. Орон нутгийн боловсролын салбарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлгээ дүгнэлт хийх,

6.3.3. Төсвийн төсөл, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, судалгаа гаргах, тайлагнах, төсөв, зардлыг ил тод мэдээлэх;

6.3.4. Салбарт хэрэгжиж байгаа гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүгийн зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах,

6.3.5. Орон нутгийн боловсрол, соёлын салбарын хөгжил, үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг тандах судалгаа, оношилгоо хийх,

6.3.6. Цэцэрлэг, сургууль, мэргэжлийн боловсролд хамрагдах хүүхдийн ойрын болон хэтийн төлөвийн таамаглал боловсруулах, бусад шаардлагатай тооцоо, судалгаа хийх,

6.3.7. Тайлан, мэдээ мэдээллийг судалгаа, баримт нотолгоонд тулгуурлан үнэн зөв, чанартай боловсруулах,

6.3.8. Судалгаанд тулгуурлан цэцэрлэг, сургуулийн бүтэц, хэв шинжийг оновчтой тогтоох, өөрчлөн байгуулах, цэцэрлэг, сургуулийн ачааллын тэнцвэрт байдлыг хангах, дахин төлөвлөлт хийх, цэцэрлэгт, сургууль шинээр барих, өргөтгөх санал боловсруулж шийдвэрлүүлэх,

6.3.9. Сургалтын байгууллагын барилга, байгууламж, сургалтын хэрэглэгдэхүүн, цэцэрлэг, сургуульд хамрагдаж буй хүүхэд, багш, ажилтны шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийн мэдээлэл тогтмол цуглуулж судалгаа хийх,

нэгдсэн системийг бүрэн хөтлөх, ашиглах, холбогдох газруудыг мэдээллээр хангах

НАЙМ. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

8.1. Ажилтан сонгон шалгаруулах талаар

8.1.1 Боловсролын газар нь төрийн жинхэнэ албанд болон төрийн үйлчилгээний ажилтан сонгон шалгаруулж авахдаа Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн хүрээнд шударга, ил тод, нээлттэй сонгон шалгаруулалтын зарчим баримтлан ажиллана.

8.2. Хүний нөөцийг чадваржуулах талаар

8.2.1 Боловсролын газар нь төрийн захиргааны албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн дор дурьдсан арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

- Боловсролын газрын албан хаагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр ажлын байрны чиг үүргийн дагуу мэргэшүүлэх сургалтанд хамруулах,
- Боловсролын газрын албан хаагчдыг ажлын байранд нь сургаж, дадлагажуулах чиглэлээр мэдээллийн технологи, албан хэрэг хөтлөлт, компьютерийн зарим хэрэглээний программын сургалтыг зохион байгуулах,
- Боловсролын газрын албан хаагчдыг багаар ажиллах чадварыг дээшлүүлэх, хэвшүүлэх, ажил хэргийн ур чадварыг сайжруулах, тодорхой асуудлаар үүрэг, даалгавар өгөх,

8.2.2 Газрын албан хаагчдыг 2025-2029 онд төрийн захиргааны болон салбарын чиглэлээр мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх чиглэл:

- Удирдлага манлайллын менежмент
- Хүний нөөцийн удирдлага
- Мэдээллийн технологи
- Мэргэжлийн онолын мэдлэг
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ
- Эрх зүйн сургалт
- Хэлний сургалт

8.3. Хүний нөөцийн зохион байгуулалт

Боловсролын газар нь Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, Сургалт, судалгаа арга зүйн хэлтэс гэсэн 2 хэлтэстэйгээр үйл ажиллагаагаа зохион байгуулна

Хүний нөөцийн бүртгэл мэдээллийг тогтмол хөтөлж, төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах, шатлан дэвшүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах зэрэг Төрийн албаны тухай хууль, журмын дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.

АРАВ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явц болон эцсийн үнэлгээг Боловсролын газрын жил бүрийн ажлын тайлантай хамтатган хийнэ. Баримт бичигт тусгагдсан стратегийг хэрэгжүүлснээр дараах гол үр дүнд хүрнэ.

Д/д	Үр дүн	Хүрэх түвшин
10.1	Боловсролын газраас ПТК, ЕБС, СӨББ-д үзүүлэх зөвлөн туслах үйл ажиллагааны хүртээмж, чанар нэмэгдсэн байх	Зөвлөн туслах үйл ажиллагааг хүргэх сургууль, цэцэрлэг. 2024-2025 оны хичээлийн жилд 8 сургууль, 15 цэцэрлэг 2025-2026 оны хичээлийн жилд 10 сургууль, 15 цэцэрлэг 2026-2027 оны хичээлийн жилд 10 сургууль, 15 цэцэрлэг, 1 МББ 2027-2028 оны хичээлийн жилд 10 сургууль, 15 цэцэрлэг 2028-2029 оны хичээлийн жилд 10 сургууль, 15 цэцэрлэг, 1 МББ Сургалтын байгууллагын тоо -80 Хэрэгжилтийн хувь-100%
10.2	Олон нийтийн оролцоонд тулгуурласан бодлого боловсруулах, үйлчилгээ үзүүлдэг болсон байх	Боловсролы салбарын хэмжээнд дэвшүүлж байгаа бодлого, зорилтыг тодорхойлоход эцэг, эх, олон нийтийн санал, бодлыг тусгадаг болсон байна
10.3	Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг амжилттай хэргжүүлж, хүүхэд бүрийг хөгжүүлж чадсан багш сурган хүмүүжүүлэгчдийн арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан байх	Харилцан туршлага солилцох зөвлөгөөнийг 6 бүсийн төвийг түшиглэн жил бүр зохион байгуулсан байна. Арга зүй технологийн санд шилдэг арга зүйтэй багш нарын туршлагыг бүртгэж авсан байна. /2029 онд нийт багшийн 30 хувь/
10.4	Салбарын хэмжээнд хийгдсэн хөрөнгө оруулалтын үр дүнд цэцэрлэг сургуулийн сургалтын орчин сайжирч, хамран сургалт өмнөх онуудаас өссөн байх	Хамран сургалтын хүрэх түвшин СӨББ-ын хамран сургалт /2015 онд 83,1 хувь/ 2024-2025 оны хичээлийн жилд 84 хувь 2025-2026 оны хичээлийн жилд 85 хувь 2026-2027 оны хичээлийн жилд 87 хувь 2027-2028 оны хичээлийн жилд 90 хувь 2028-2029 оны хичээлийн жилд 92 хувь ЕБС-ийн хамран сургалт /2015 онд 94,4 хувь/ 2024-2025 оны хичээлийн жилд 95 хувь 2025-2026 оны хичээлийн жилд 95,4 хувь 2026-2027 оны хичээлийн жилд 96 хувь

		• 2027-2028 оны хичээлийн жилд 96,5 хувь • 2028-2029 оны хичээлийн жилд 97,0 хувь
10.5	Бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж тогтвортой байх	Элсэлтийн шалгалтын хэмжээст онооны дундаж /2024 онд 517 оноо / • 2025 онд 518 оноо • 2026 онд 520 оноо • 2027 онд 522 оноо • 2028 онд 524 оноо • 2029 онд 526 оноо
10.6	Удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг боловсролын байгууллагуудад нэвтрүүлсэн байх	Удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлнэ. • 2024-2025 оны хичээлийн жилд ЕБС-ийн хүний нөөцийн модуль, ЕБС-ийн статистик мэдээлэл • 2025-2026 оны хичээлийн жилд СӨББ-ын статистик мэдээлэл
10.7	Боловсролын сургалтын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд жил бүр хамрагдаж, үнэлгээний дундаж үзүүлэлтийг ахиулсан байна.	• 2024-2025 оны хичээлийн жилд ... хувь • 2025-2026 оны хичээлийн жилд ... хувь • 2026-2027 оны хичээлийн жилд хувь • 2027-2028 оны хичээлийн жилд хувь • 2028-2029 оны хичээлийн жилд ... хувь
10.8	Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ажилтнуудыг үндэсний болон орон нутгийн үндсэн сургалтанд бүрэн хамруулсан байна.	Үндсэн сургалтанд хамрагдах багш нарын тоо • 2024-2025 оны хичээлийн жилд-400 • 2025-2026 оны хичээлийн жилд-428 • 2026-2027 оны хичээлийн жилд-443 • 2027-2028 оны хичээлийн жилд-475 • 2028-2029 оны хичээлийн жилд-475
10.9	Байгууллагын төсвийн болон үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хэвшүүлсэн байх	Боловсролын газрын цахим хуудас болон мэдээллийн самбарт аливаа мэдээллийг цаг тухайд нь тогтмол байршуулж, пэйж хуудас хөгжүүлэлтийг хангана
10.10	Гадаад оронд багш, удирдах ажилтнуудын мэргэжил боловсролыг дээшлүүлсэн байх	Гадаад оронд мэргэжил, боловсролоо дээшлүүлсэн багш, удирдах ажилтны тоо • 2024-2025 оны хичээлийн жилд -50 • 2025-2026 оны хичээлийн жилд -100 • 2026-2027 оны хичээлийн жилд -100 • 2027-2028 оны хичээлийн жилд -100 • 2028-2029 оны хичээлийн жилд -100